



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 дугаар сарын 23

№01/26 ДУА-2018/83/СТА-ТЦЗ Мандалговь хот

Г Төлбөр барагдуулах тухай Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар албан томилолтыг **93,000.00** /Ерин гурван мянган/ төгрөгөөр илүү тооцож олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 3.9-д /Албан томилолтоор ажилласан хоногийн тоог томилолтын үнэмлэхэд тэмдэглэсэн календарийн хоногоор гаргаж тооцно. Тэгэхдээ явсан, буцаж ирсэн өдрийг нэг хоногт тооцно/ гэж заасныг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.3-д /Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тооцож олгосон **93,000.00** /Ерин гурван мянган/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж 100080000955 дугаар дансанд 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор тус тус төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2018 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн шууд захирагч Б.Амгаланжаргал, нягтлан бодогч Б.Сайхантуяа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН¹:

АУДИТОР  ОЮУН-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА 

Б.АМГАЛАНЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ 

Б.САЙХАНТУЯА

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.